



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 4/112

Булган сум

Орон нутгийн нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг төсвийн шууд захирагчдад 2025 оны төсвийн жилийг дуустал олгох орон нутгийн нэмэгдлийг хавсралтаар баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг ханган шаардагдах санхүүжилтийг сар бүр олгож ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотой аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Б/11 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025. оны
02 дугаар сарын 09-ны/ний өдрийн А/117 дүгээр
захирамжийн хавсралт



Төсвийн шууд захирагчийн нэр

Д/д	Байгууллагын нэр	Орон нутгийн төсвөөс олгох орон нутгийн нэмэгдлийн хувь
1	2	3
Орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч		
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	40
2	Байгаль орчны газрын дарга	40
3	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга	40
4	Орон нутгийн өмчийн газрын дарга	40
5	Худалдан авах ажиллагааны газрын дарга	40
Улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч		
1	Шүүхийн тамгын газрын дарга	20
2	Биеийн тамир, спортын газрын дарга	20
3	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга	20
4	Татварын газрын дарга	20
5	Эрүүл мэндийн газрын дарга	20
6	Боловсролын газрын дарга	20
7	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга	20
8	Нийгмийн даатгалын газрын дарга	20
9	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга	20
10	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга	20
11	Статистикийн хэлтсийн дарга	20
12	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга	20
13	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга	20
14	Мал эмнэлгийн газрын дарга	20
15	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга	20
16	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	20
17	Хануй голын сав газрын захиргааны дарга	20